ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Ж-2-ЕР-40-02

# Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх журам

ЭХ ХУВЬ 1

<table>
<tr><td colspan="5">Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Стратеги төлөвлөлт санхүү бүртгэлийн алба</td></tr>
<tr><td colspan="2">Баримт бичгийн дугаар:</td><td colspan="3">Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх журам</td></tr>
<tr><td>Хувилбар №02</td><td>Хэрэгжиж эхэлсэн огноо: 2016.07.01.</td><td>Өөрчлөлт 0</td><td>Өөрчлөлт хийн шинэчилсэн огноо: 2018.05.21</td><td>Хуудас 1/9 нийт хуудасны тоо</td></tr>
</table>

| Боловсруулсан: | Хянан засварласан: | Хянасан: | Баталсан: |
|---|---|---|---|
| Статистикч, эдийн засагч | СТСБА-ны дарга | ЧЦСС-ийн албаны дарга | ЦССҮТ –ийн захирал |
| Л.Өнөрбаяр | Ч.Батболд | Т.Алимаа | Н.Эрдэнэбаяр |
| Огноо: | Огноо: 2018.05.21 | Огноо: | Огноо: |
| Гарын үсэг | Гарын үсэг | Гарын үсэг | Гарын үсэг |

| Өөрчлөлт хийгдээгүй | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|
| Зөвшөөрсөн | ЭШМТАЗ IT инженер | |
| Хянасан | ЦЦСС-ийн албаны дарга. | |
| Хүчинтэй хугацаа | 2020 он 05 сар 21 өдөр | |

| Өөрчлөлт хийгдээгүй | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|
| Зөвшөөрсөн | ЭШМТА-дарга | Л.Өнөрбаяр. |
| Хянасан | ЦЦССА дарга | |
| Хүчинтэй хугацаа | 2021 он 05 сар 21 өдөр | |

| Өөрчлөлт хийгдээгүй | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|
| Зөвшөөрсөн | | |
| Хянасан | ЦЦАБА дарга | |
| Хүчинтэй хугацаа | 2022 он 05 сар 21 өдөр | |

## ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

| Д.д | Хуудас № | Бүлэг № | Өөрчлөлт оруулсан огноо | Оруулсан өөрчлөлтийн утга | Шалтгаан | ЧАД-н гарын үсэг | Даргын гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |

Агуулга


| Д/д | Бүлэг | хуудас |
|---|---|---|
| 1. | Өөрчлөлт оруулсан бүртгэл | 3 |
| 2. | Агуулга | 4 |
| 3. | Зорилго | 5 |
| 4. | Хамрах хүрээ | 5 |
| 5. | Хариуцлага, эрх үүрэг | 5 |
| 6. | Тодорхойлолт, товчилсон үг | 5 |
| 7. | Журмаар зохицуулах үйл ажиллагаа | 5-9 |
| 8. | Лавлах, эш татсан материал | 9 |
| 9. | Хавсралт | 9 |
| 10. | Холбогдох баримт бичиг | 9 |

1. **Зорилго**: Энэхүү журмыг Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 01 тоот тушаалын 01 дүгээр хавсралтын 1.5-д заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс жилд 1 удаа цусны салбар төвүүдийн үйл ажиллагааг дүгнэн, байр эзлүүлж, шагнаж урамшуулан сайн туршлага түгээн дэлгэрүүлэхэд ашиглана.
2. **Хамрах хүрээ:** Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн (ЦССҮТ-ийн) салбар төвүүд энэ журмыг мөрдөнө.
3. **Үүрэг хариуцлага:** Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх үнэлгээний үр дүн

- Гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр тэргүүлсэн болон "Маш сайн" үнэлгээ авсан эхний 3 Цусны салбар төвүүдийг шагнаж урамшуулан сайн туршлага түгээн дэлгэрүүлнэ.
- Үнэлгээний дүнгээр "Дутагдалтай", "Хангалтгүй" гэж дүгнэгдсэн Цусны салбар төвүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.
- Шагнал, урамшуулалд зарцуулах хөрөнгийг ЦССҮТ-ийн төсөвт жил бүр тусгана.

3. **Товчилсон үг:**
   - ЦССҮТ- Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв
   - ЭШХНХА- Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагаа
   - ЧЦСС- чанар, цусны сонор сэрэмж
   - САЗ- Стандар ажиллагааны заавар
   - ТТАЗ- Тоног төхөөрөмж ажиллуулах заавар
   - ЧА- Чанарын алба
   - Ж- журам
   - ДЭМБ – Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

4. **Журмаар зохицуулах үйл ажиллагаа**

**Цусны салбар төвүүдийн үйл ажиллагааг дараах үзүүлэлтүүдийг дагуу дүгнэнэ.**

Удирдлага зохион байгуулалт:

- Бүтэц, үйл ажиллагааны стандарт болон холбогдох тушаалуудын хэрэгжилтийн байдал
- Харъяа сум, харилцагч эмнэлэг, тасаг нэгжүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран ажилласан байдал
- Нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллагын төсөл хөтөлбөрөөр асуудал шийдвэрлүүлсэн байдал

- Мэдээ тайлан нэгтгэл, цаг хугацаанд нь хүргүүлсэн байдал
- Цусны албанаас зохион байгуулсан цахим сургалтанд оролцсон байдал

дотоод хяналтын шалгалтаар

Чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилт:

- Чанарын бодлого, чанарыг нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилтоо тодорхойлон төлөвлөлт, тайлагналт
- Чанарын үзүүлэлтийг тодорхойлж үр дүнг тооцсон байдал
- Тухайн жилд шинээр боловсруулсан, хянан зассан САЗ, ТТАЗ, АЗ, АШМ-ын тоо
- Чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүн
- Цусны аюулгүй байдлыг хангах болон чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүн
- Үйлчлүүлэгчийн санал хүсэлтийн дагуу хэрэгжүүлсэн ажлууд
- Илрүүлсэн алдаа, зөрчлийн тоо, засч, сэргийлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ

Донор зохион байгуулалт, цус, сийвэн цуглуулалт:

- Донорын сургалт, сурталчилгаа хийдэг арга хэрэгсэл, хамрагдсан хүн амын тоо, үр дүн
- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан байдал
- Цус, сийвэн цуглуулах төлөвлөлт, биелэлт
- 1 000 хүн амд ногдох цус өгөлтийн тоо
- Нийт донорын дунд шинээр нэмэгдсэн донорын тоо, өмнөх оноос өсөлт, бууралт
- Нийт донорын дунд байнгын донорын эзлэх хувь, өмнөх оноос өсөлт, бууралт
- Донорын сонор, сэрэмжийн тогтолцооны хэрэгжилт, урвал хүндрэл, баримтжуулалт
- "Цусны донорын дэлхийн өдөр" зохион байгуулсан ажлын тайлан

Донор болон цуглуулсан цус, сийвэнгийн нэгжид хийсэн шинжилгээ:

- Цуглуулсан цусанд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээ хийсэн тоо, төрөл, хасагдалтын хувь өмнөх оноос өсөлт, бууралт
- Иммуногематологийн шинжилгээний нэр төрөл, баталгаажуулах шинжилгээ хийсэн байдал

- Цус, цусан бүтээгдэхүүнд хийсэн чанарын шинжилгээний төрөл, хамрагдалтын хувь, үр дүн
- ЦЦБ-ий чанарын шинжилгээнд дээж ирүүлсэн хувь, шинжилгээний шаардлага хангасан хувь
- Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт хамрагдсан байдал, үр дүн
- Ийлдсийн сан бүрдүүлэлтийн хувь, баримтжуулалт

Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл:

- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, хэрэгцээнд уялдуулсан байдал
- Үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, нэгж
- Эмнэлэгт олгосон цус, цусан бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, нэгж
- Акталсан цус, цусан бүтээгдэхүүний, хэмжээ, нэгж, шалтгаан
- Олгогдоогүй цус, цусан бүтээгдэхүүний хэмжээ, нэгж, нэр төрөл, шалтгаан
- Цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, нөхөн хангалт /хамгийн их, хамгийн бага/
- Цус, сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөлийн хэрэглээний тайлан

Сургалт, эрдэм шинжилгээ

- Цусны аюулгүй байдлыг хангаж, зохистой хэрэглээг хэвшүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүн
- Салбар төвийн эмч мэргэжилтнүүддээ хийсэн сургалтын тоо /тасралтгүй сургалт энд хамрагдана/
- Тайлант хугацаанд хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд, хэлэлцүүлсэн болон хэвлүүлсэн байдал

**Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх үнэлгээний аргазүй**

- Гүйцэтгэлийн үнэлгээг ЦССҮТ-ийн алба, тасгийн удирдлагууд энэхүү журмын 2-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хамтран гүйцэтгэнэ.
- Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ нь энэхүү журмын 2.1-2.5 дахь хэсэг тус бүрийг 20 хувиар үнэлэх ба нийлбэр оноо 100 хувь байна. Үнэлгээний хувь болон үсгэн үнэлгээг энэхүү журмын 3.4-д заасны дагуу тодорхойлно.
- Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоходоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
    - Тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн, биелэлт хангалттай сайн бол 91-100%;

- Тавьсан зорилгодоо бүрэн хүрээгүй боловч тодорхой арга хэмжээ авсан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарсан бол 81-90%;
- Тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр дутмаг бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 71-80%;
- Тавьсан зорилгодоо бүрэн хүрээгүй, гүйцэтгэл нь дутмаг бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 61-70%;
- Тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг 60-аас доош хувь буюу F үнэлгээтэй гэж үзнэ.

- Ерөнхий үнэлгээний оноог үндэслэн дор дурьдсан үнэлгээний аль нэгийг өгнө. Үүнд:

| | |
|---|---|
| Маш сайн | 91-100 хувийг хангаж байвал “A” |
| Сайн | 81-90 хувийг хангаж байвал “B” |
| Хангалттай | 71-80 хувийг хангаж байвал “C” |
| Дутагдалтай | 61-70 хувийг хангаж байвал “D” |
| Хангалтгүй | 60-аас доош хувьтай бол “F” үнэлгээтэй гэж үзнэ. |

## Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааны тайлан бичих заавар

Нэг. Цусны салбар төвүүдийн үйл ажиллагааны тайлан дараах үлгэрчилсэн бүтэцтэй байна.

- Нүүр хуудас
- Гарчиг
- Үндсэн хэсэг
    - Удирдлага зохион байгуулалтын талаар хийсэн ажлын төлөвлөгөө, тайлан, баримтжуулалт
    - Чанарын удирдлагын тогтолцооны талаар хийсэн ажлын төлөвлөгөө, тайлан, баримтжуулалт
    - Донор зохион байгуулалт, цус, сийвэн цуглуулалтын төлөвлөгөө, тайлан, баримтжуулалт
    - Цуглуулсан цусны нэгжид хийсэн шинжилгээний тайлан, баримтжуулалт
    - Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төлөвлөгөө, тайлан, баримтжуулалт
- Хавсралт

Тайлангийн тайлбар, агуулга

- Нүүр хуудас нь Цусны салбар төвийн нэр, Эрхлэгч эмчийн нэр, гарын үсэг, он сар гэсэн мэдээллүүдийг агуулна.
- Гарчиг нь ажлын бүлэг ба зүйлүүдийн нэр, хуудасны дугаарыг агуулсан байна.
- Үндсэн хэсэгт батлагдсан журмын дугаар, номерын дагуу үндсэн үйл ажиллагааны талаар хийгдсэн ажлын тайлан, баримтжуулалтыг агуулсан байна.
- Хавсралт хэсэгт баримтжуулалт болон бусад материалыг агуулж болно.
- Тайланг бичихдээ А4 хэмжээний цаасан дээр зүүн талд нь 25мм, дээд, доод болон баруун талаас 20 мм зайтай байх ба хуудсыг дугаарласан байна. Мөн мөр хоорондын хэмжээ нь 1-1,25 байх ба үсгийн хэмжээ arial 12 байна.

## 6. Лавлах материал

6.1. ДЭМБ-ын Чанарын удирдлагын тогтолцооны сургалтын материал
6.2. MNS ISO 9001: 2016 стандарт

## 7. **Хавсралт-** хамаарахгүй

## 8. Холбогдох баримт бичиг

8.1. Баримт бичиг боловсруулах журам Ж- ЧА- 2- 1-1
8.2. Баримт бичиг дугаарлах, танин тодруулах, кодлох журам Ж- ЧА- 2- 2-1
8.3. ЭМ-ийн Сайдын Цусны донор сонгох шалгуур үзүүлэлт, эрүүл мэндийн карт, сорьц авах, ийлдсийн сан бүрдүүлэх, захиалга олгох, эргэн мэдээлэл хийх тухай 2016 оны 2 тоот журам
8.4. Цусны төвийн үйл ажиллагаа, цусны аюулгүй байдал хангах, хяналт үнэлгээ хийх тухай 2016 оны 1 тоот журам
8.5. ЭМ-ийн Сайдын ЭМ-ийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай 450 тоот тушаал